



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТИН ГАЗАР
81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

ГАЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРООНД

2024. 08. 09 № 418
танай -ны № -т

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Орон нутгийн Хурлын сонгуульд оролцох Монгол Ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Орон нутгийн Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аudit MNS 6817 - 1 : 2020 Төрийн аudit. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аudit. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аudit. Нийцлийн аudit стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт


Монгол Ардын намын /РД: 8488908/ Орон нутгийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5

дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Монгол Ардын намын мөрийн хөтөлбөр (25 хуудас)-ийг хавсаргав.


Хувийг: Монгол Ардын намд

Хавсралт 25 хуудастай.



ЗАВХАН АЙМГИЙН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНЫ 2024 ОНЫ ОРОН НУТГИЙН ИТХ-ЫН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Ирэх 4 жил Завхан аймаг эдийг засгийн өсөлт, хувийн хэвшлийн хөгжил, хүний хөгжил, хөдөө аж ахуйн хөгжлийг тэргүүн ээлжинд дэмжиж ажиллана. Дэд бүтцийн өрсөлдөх чадвар, засаглалын ил тод байдалдаа үлэмж их ахиц дэвшил гаргана. Боловсролын чанар, өрсөлдөх чадвараараа улсаа тэргүүлнэ.




ЗАСАГЛАЛ САЙТАЙ ЗАВХАН

- Сумдын давсан орлогыг аймаг татан авдагаа болж, өөрсдөө орлогоо захиран зарцуулах эрхийг сумдад олгоно.
- Аймгийн Тосонцэнгэл, Улиастайгаас бусад 22 сумыг инженерийн шийдэл бүхий дэд бүтэц бүхий системтэй болгох бодлогыг боловсруулж шат дараалалтайгаар хэрэгжүүлж эхэлнэ /дулаан, цэвэр ус, бохирын систем/
- Орон нутгаас олгодог тусгай зөвшөөрөл бүхий үйл ажиллагаа эрхлэх иргэд, ААН байгууллагуудыг дэмжин ажиллана. Стандартын шаардлага хангасан үйлчилгээний байгууллагад олгох зөвшөөрлийг шуурхай хүндрэл багатайгаар олгодог болгоно.
- Орон нутгийн төсвийг иргэдийн саналд үндэслэн батлана. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг ач холбогдоор нь эрэмбэлнэ
- Иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагааг бүх талаар дэмжиж, тэднийг чадавхижуулж хамтран ажиллана.
- Бүх багуудын өдөрлөгийг жил бүр тогтмол хийж хэвшүүлж, төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэдэг болгоно
- Авто машины парк шинэчлэлийг хийх шаардлагатай төрийн байгууллагын судалгааг гаргаж улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийх дуусгана.

- Завхан аймагт үйл ажиллагаа явуулдаг уул уурхайн аж ахуйн нэгжүүд худалдан авалтаа Завхан аймгаас хийдэг болох бодлого хэрэгжүүлнэ

ЦАХИМ ЗАВХАН

- Орон нутгийн бодлого төлөвлөлтийг ил тод, нээлттэй байлгана
- Төрөөс орон нутагт үзүүлж буй төрийн бүх үйлчилгээг цахимжуулна
- Завхан аймгийн өнгөрсөн хугацаанд хийсэн дунд болон, ут хуацааны хөтөлбөрүүд мөн холбогдох мэдээлэл өгөгдөл дээр тулгуурласан бодлого хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ



ХҮНИЙ ХӨГЖЛИЙГ ДЭМЖСЭН ЗАВХАН


- Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэх болон чадавхижуулах зорилгоор “Англи хэлтэй Завхан” хөтөлбөр хэрэгжүүлнэ
- Англи хэлний багш нарыг гадаадад мэргэжил дээшлүүлэх, чадавхижуулах ажлыг дэмжин ажиллана
- Улс, бус, олон улсын тэмцээн, уралдаан, олимдиадад оролцох, багш сурагчийн зардалд дэмжлэг үзүүлэх тогтолцоог бодлогоор дэмжинэ.
- Хүүхэд залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд зориулсан кино театрыг ашиглалтад оруулж, орчин үеийн кино үзвэр үйлчилгээгээр бүрэн үйлчилдэг болно
- Төрийн албан хаагчдыг чадавжжуулахад чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- Хөдөлмөрийн уян хатан зохицуулалт, ажил амралтын тэнцвэрт байдлыг бий болгоно
- Аймгийн хэмжээний 116 багийн дарга, багийн эмч нарын судалгааг гарган шаардлагатай багийн дарга, эмчийг унаагаар хангана.

- Эмч нарыг мэргэжил дээшлүүлэх, гадаад, дотоодод сургах хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- Ахмадуудыг дэмжсэн хөтөлбөрийг хэрэгжүүлнэ
- Ахмад эмч, ахмад багш нарын зөвлөх үйлчилгээг дэмжиж хэрэгжүүлнэ
- Отгонтэнгэрийн рашаан сувилалын хувьчлалыг буцааж, үйл ажиллааганы менежментийг сайжруулан ахмадуудыг жил бүр амраадаг болгоно-засах
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төвийг байгуулж, орчин үеийн тоног төхөөрөмжөөр хангана
- Насан туршийн боловсролын төвөөр дамжуулан залуучууд, малчид, бизнес эрхлэгчид, төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх төрөл бүрийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлнэ

БОЛОВСРОЛТОЙ ЗАВХАН

- Завхан аймгийн Ерөнхий боловсролын сургуулиудад Олон улсын хөтөлбөрийг нэвтрүүлнэ.
- Завхан аймгийн Ерөнхий боловсролын сургуулийн 12-р анги төгсөгчид дотоодын сургуулиудаас гадна гадаадын сургуульд шууд элсэн суралцах боломж нөхцөлийг бүрдүүлнэ.
- Политехник коллежид Олон улсын хөтөлбөрийг нэвтрүүлнэ.
- Политехник коллежийн оюутнуудыг гадаадад үргэлжлүүлэн сургах хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- МУИС-ийн харьяа Завхан Их сургуулийг баруун бүсийн мэдээллийн технологийн төв болгож хөгжүүлнэ.
- Боловсролын чанар, элсэлтийн ерөнхий шалгалтын үнэлгээгээр улсын хэмжээнд тогтмол эхний байруудад орох бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлнэ

- Олон улсын стандартад нийцсэн нийтийн номын санг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барьж ашиглалтад оруулна
- Олон улсын стандартад нийцсэн баруун бүсийн төв тийм музейг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барьж байгуулна
- Олон улсын стандартад нийцсэн хөл бөмбөг, сагсан бөмбөгийн талбайнуудыг барьж байгуулна
- ЕБС болон цэцэрлэгийн орчныг бүрэн камержуулж эрсдэлээс сэргийлнэ
- Аймгийн хэмжээний ерөнхий боловсролын сургуулиудыг гадаад багштай болгох бодлого хэрэгжүүлнэ.
- Боловсролын салбарыг улс төрөөс ангид байлгаж, мэргэжлийн ур чадварыг эрхэмлэнэ.




ЭРҮҮЛ МЭНДЭЭ ХАМГААЛСАН ЗАВХАН

- Аймгийн хэмжээнд нийт иргэдийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоог жил бүр хийж хэвшүүлнэ
- Явуулын үзлэг оношлогоог хөдөөгийн багуудад ажиллуулж хэвшүүлнэ
- Улсын нэгдсэн I, II, III, Хавдар судлалын үндэсний төв эмнэлгүүдтэй хамтын ажиллагаагаа өргөжүүлж, жил бүр хамтарсан үзлэгүүдийг явуулна
- Завхан аймгийн хэмжээнд өндөр өвчлөлтэй байгаа хорт хавдар, зүрх судас, амьсгалын замын өвчлөлийг бууруулах бодлого хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ
- Аймгийн төвд шинээр баригдах нэгдсэн эмнэлгийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар олон улсын стандартад нийцсэн тоног төхөөрөмжөөр бүрэн хангана
- Эрүүл амьдралын хэв маягыг хэвшил болгож, нийтийн биеийн

тамираар хичээллэх орчин нөхцөлийг эрс сайжруулна

- Уламжлалт анагаах ухааныг аялал жуулчлал, рашаан сувилалтай хослуулан хөгжүүлэх сайн жишгийг нэвтрүүлнэ




БИЗНЕСТЭЙ ЗАВХАН

- Завхан аймгийн жижиг дунд үйлдвэрлэл, гарааны бизнесийг дэмжих “Завхан бизнес кластер”-ийг байгуулж, хувийн хэвшил, иргэний нийгмийн оролцоотойгоор өргөжүүлэн хөгжүүлнэ
- “Завханд үйлдвэрлэв” бүтээгдэхүүнүүдийг улсын хэмжээний сүлжээ дэлгүүр, худалдааны төвүүдээр дамжуулан борлуулах сүлжээг байгуулна
- Бизнес эрхлэлтийг дэмжсэн жижиг зээлийг орон нутгийн төсвөөс дэмжиж, сонгон шалгаруулалтыг ил тод нээлттэй болгоно
- Уул уурхайн компаниудтай нийгмийн хариуцлагын гэрээг байгуулж, орон нутгийг дэмжсэн бодлогыг нээлттэй ил тод болгоно
- Барилга барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлж, ААН хувийн хэвшлийн барилгын материалын үйлдвэрлэлийг бодлогоор дэмжиж ажиллана
- Арцуурийн боомтын цогцолборын ажлыг эхэлүүлж боотмын хүчин чадал нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэн гадаад худалдааг дэмжин ажиллана
- Орон нутагт үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний нэр тоо хэмжээг нэмэгдүүлэн чанар, сав баглаа боодол, хаяг шошгийг сайжруулан орон нутагт орох орлогыг нэмэгдүүлнэ
- Хувийн хэвшлийг дэмжих замаар малын гаралтай түүхий эд тэр дундаа мах, сүү, арьс шир, ноос ноолуур боловсруулах бага оврын үйлдвэрлэл, цехийг сум бүрд байгуулна
- Тэжээвэр амьтад буюу гахайу аж ахуй, шувууны аж ахуй, зөгийн аж

ахуй эрхлэх, дулаалгатай хүлэмж байгуулах, жимс, жимсгэнэ тариалах хувийн хэвшлийг аж ахуйн нэгжүүдийг бодлогоор дэмжинэ

- Улиастай, Тосонцэнгэл сумд орчин үеийн стандартын шаардлага хангасан 1000 тонны хүнсний ногооны зоорийг хувийн хэвшилтэй хамтран, төсөл хөтөлбөрийн хүрээнд барьж байгуулна
- Төмс, хүнсний ногооны хэрэгцээгээ аймаг өөрөө бүрэн хангадаг болох зорилтыг хэрэгжүүлнэ




ДЭД БҮТЭЦТЭЙ ЗАВХАН

- Аймгийн бүх сумдын төвийн 0.4 кВт-ын ЦДАШугамыг- шинэчлэн өргөтгөнө
- Улиастай хотын дулааны цахилгааны станц ашиглалтай орохтой холбогдуулан бүх байгууллага, орон сууцыг дулаантай холбоно /жинст, богдын гол баг/
- Аймгийн хэмжээнд хог хаягдлын менежментийг сайжруулах, иргэд айл өрхүүдэд хог хаягдлын талаарх ойлголтыг сургах, хэвшүүлэх ажлыг ТББ-уудтай хамтран хэрэгжүүлнэ. Хог хаягдлыг шатаах зуухнуудыг ашиглалтад оруулж, хог хаягдлын менежментийг сайжруулах хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ
- Улиастай хотын гэр хорооллын эрчим хүчний асуудлыг бүрэн шийдвэрлэнэ
- Улиастай хотын гэр хорооллын дахин төлөвлөлтийг шинээр хийж сайжруулна
- Арц суурь-Нэмрөг чиглэлийн авто замыг барьж байгуулах бодлогыг хэрэгжүүлнэ. Үүний үндсэн дээр Тэс, Баянтэс, Асгат, Баянхайрхан, Түдэвтэй сумдыг авто замтай холбох бодлогыг хэрэгжүүлнэ.
- Завхан Говь-Алтай чиглэлийг авто замыг ашиглалтад оруулах бодлогыг дэмжинэ. Энэ бодлогын хүрээнд Цагаанхайрхан,

Цагаанчууут, Отгон, Шилүүстэй сумдыг авто замаар холбох бодлогыг дэмжиж хэрэгжүүлнэ.


- Улиастай-Ховд аймгийг авто замаар холбох бодлогыг дэмжинэ. Энэ бодлогын хүрээн Эрдэнэхайрхан, Завханандал, Дөрвөлжин, Ургамал сумдыг авто замаар холбох ТЭЗҮ-ийг улсын төсийн хөрөнгө оруулалтаар хийнэ
- Засгийн газрын аймгуудыг авто замаар холбох бодлогын хүрээнд Завхан-Баянхонгор, Завхан-Хөвсгөл аймгийг авто замаар холбох бодлогыг дэвшүүлж, техник эдийн засгийн үндэслэлийг хийлгэнэ



АЯЛАЛТАЙ ЗАВХАН

- Өвлийн аялал жуулчлалыг дэмжих бодлого хэрэгжүүлнэ
- Адал явдалт аялал жуулчлалыг хөгжүүлнэ
- Хил орчмын бүсийн аялал жуулчлалыг хөгжүүлнэ
- Ангийн аялал жуулчлалын хөтөлбөрийг Байгаль орчны яамтай хамтран хэрэгжүүлнэ.
- Аялал жуулчлалын тогтмол арга хэмжээг жил бүр зохион байгуулж хэвшинэ
- Гадаад дотоодын жуулчдын тоог 2 дахин нэмэгдүүлнэ
- Отгонтэнгэр нисэх буудалд аяллын, иргэний агаарын жижиг онгоцнуудыг тогтмол буулгах, ийм төрлийн үйлчилгээг дэмжиж хэрэгжүүлнэ
- Тосонцэнгэлийн нисэх буудлыг иж бүрэн шинэчилж, тогтмол нислэг хүлээн авдаг болгоно
- Аялал жуулчлалын цэгүүдийн ариун цэврийн байгууламж, түр буудаллах, отоглох цэгийг байгуулж, хог хаягдлын менежментийг бүрэн шийдвэрлэнэ

- Завхан аймгийн түүх, соёл, өв уламжлалыг олон улсын болон дотоодын экспо, маркетинг, нийгмийн сүлжээний сурталчилгаа зэрэг олон төрлөөр дамжуулан сурталчилна
- Отгонтэнгэр, Улаагчны хар нуур, Мухартын голыг түшиглэсэн аялал жуулчлалын тусгай бүс, эко паркийг хувийн хэвшлийн оролцоотойгоор барьж байгуулна



НОГООН ЗАВХАН

- Хөв цөөрөм, далан байгуулах “Ус” хөтөлбөр хэрэгжүүлнэ
- Шинээр мод тарих, жимсний төгөл байгуулах “ОЙ” хөтөлбөр хэрэгжүүлнэ
- Арцыг Улиастай орчим, төв зам дагуу тарьж ургуулан эдийн засгийн эргэлтэд оруулах “Арц” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ
- Айл болгон хашаандaa мод тарих бодлогыг хэрэгжүүлнэ
- Шинээр хөв, цөөрөм, далан байгуулах, мод тарих, ан амьтныг өстөх, арц тарих бодлогыг шинжлэх ухааны судалгаа, тооцоолол дээр тулгуурлан хэрэгжүүлнэ.

ШИНЭ ХОТТОЙ ЗАВХАН

- Улиастай хотод “1000 айлын орон сууц” хөтөлбөрийг хэрэгжүүлж, хувийн хэвшлийн дэмжлэгээр шинэ хорооллыг барьж байгуулна
- “1000 айлын орон сууц” хөтөлбөрийн хүрээнд түрээсийн орон сууцны бодлогыг цогцоор нь хэрэгжүүлнэ
- Завхан аймагт ипотекийн зээлийн хүртээмжийг нэмэгдүүлнэ
- Нийтийн орон сууцны доорх газрыг оршин суугчдад нь хувь тэнцүүлэн эзэмшүүлнэ
- Улиастай хотод Богдын гол, Жинст, Жаргалант, Чигэстэй багуудын төв

зам дагасан хашаа, орон сууцын төлөвлөлтийг шинээр хийж, жишиг гудамжийг байгуулна

- Богд, Чигэстэйн голын сав дагуу Шинэ цэцэрлэгт хүрээлэнг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барьж байгуулан үйл ажиллагааг орон нутгийн өмчийн компанийд хариуцуулна.
- Стандартад нийцсэн дугуйн зам, явган замуудыг барьж байгуулна
- Баг тус бүрд “автомашингүй гудамж” байгуулж, орчны тохижилтыг эрс сайжруулна
- “Хашаандаа сайхан амьдарцаа” хөтөлбөрийг бүх сум, сумын төвийн байгууллагуудад хэрэгжүүлнэ
- Бүх зам талбайд стандартыг мөрдүүлж, хүртээмжийг нэмэгдүүлнэ
- Улиастай хотын бүх иргэдэд 0.7 га газрыг олгоно
- Нийтийн орон сууцны барилгуудын гадна фасадыг оршин суугчдын оролцоотойгоор шинэчилж, дулаан алдагдлыг бууруулах хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- Жаргалант, Чигэстэй, Богдын гол, Жинст багийн ногоон хашаа орчмын үерийн даланг инженерийн шийдэлтэй зураг төсвөөр шинээр барина
- Богдын гол, Чигэстэйн гол дагуулж хууль бусаар олгосон газар олголтыг цуцалж, ногоон байгууламжуудыг нэмэгдүүлэн, нийтийн эзэмшлийн, соёл амралт орчин нөхцөлийг бүрдүүлэн ажиллана
- Хууль бус, зөвшөөрөлгүй олгосон газар чөлөөлөлтийг хийж, нийтийн эзэмшлийн газарт зөвшөөрөлгүй барьсан барилга байгууламжийг буулгаж оронд нь нийтийн ногоон байгууламжуудыг нэмэгдүүлнэ
- Иргэдийн тав тухтай амьдрах орчныг хангах хүрээнд, хөдөлгөөнийг хязгаарлаж буй хашаа, хаалтуудыг үргэлжлүүлэн буулгаж газрыг чөлөөлж иргэдийн тав тухай амьдрах орчныг бүрдүүлнэ

ШИНЭ ХӨДӨӨТЭЙ ЗАВХАН

- Малчдыг малжуулах, оторчдын эрүүл мэнд, мал сүргийг хамгаалсан “Оторчин” хөтөлбөр хэрэгжүүлнэ “Шинэ хоршоо” хөдөлгөөнийг дэмжиж, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэн ажиллана
- Малчдыг дэмжих, тав тухтай амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх хүрээнд “Өвөлжөө” төслийг боловсруулан хэрэгжүүлнэ
- “Шинэ хөдөө” төслийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар жил бүр хэрэгжүүлж, ногоон тэжээл тариалах, сүү сүүн бүтээгдэхүүн боловсруулах малчдын амьдралыг хөнгөвчлөх дэвшилтэт технологийг нэвтрүүлнэ
- “Худаг” хөтөлбөр хэрэгжүүлж, Завхан аймгийн хэмжээнд байгаа худгийг засварлах, шинээр гаргах ажлыг төслүүдийн хүрээнд үе шаттай хэрэгжүүлнэ
- Газар тариалангийн бүс нутгийг дагуулан эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэхийг бодлогоор дэмжин ажиллана
- “Усалгаатай газар тариалан” хөтөлбөр хэрэгжүүлж, ургацыг нэмэгдүүлэх газар тариалангийн талбайг тэлэх бодлогыг хэрэгжүүлнэ
- Малын гаралтай дайвар бүтээгдэхүүнүүдийг боловсруулах үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалтыг дэмжсэн бодлого баримтлана
- Малын үүлдэр угсааг сайжруулах хөтөлбөр бодлого, сайн туршлагыг сум бүрт хэрэгжүүлнэ




БАРУУН БҮСИЙН ТӨВ ЗАВХАН

- Баруун бүсийн спортын хөгжлийн төв болно
- Шашны аялал жуулчлалын төв болж хөгжих бодлого хөтөлбөрийг хэрэгжүүлнэ
- Баруун бүсийн мэдээлэл, технологийн төв болно

- ОХУ-БНХАУ-ыг холбосон авто замыг түшиглэн баруун бүсийн тээвэр ложистикийн төвийг байгуулж, ачаа тээврийн нэгдсэн сүлжээг үүсгэх ААН-ийг бодлогоор дэмжинэ.

АЛДАРХААН

- Сумын төвийн инженерийн шугам сүлжээний зураг төсвийг гарган өргөтгөх
- Сумын ЗДТГ-ыг шинээр барих
- Чигэстэй багийн төвийг шинээр барьж жишиг багийн төв болгох
- Газар тариалангийн үйлдвэрлэлийг дэмжих, бага оврын гурилын үйлдвэр байгуулах
- Ноос угаах, самнах үйлдвэр байгуулах
- Суманд халуун ус бүхий үйлчилгээний төв барих
- Ямаан усны цогцолборт газарт аялал жуулчлалын бүс байгуулах




АСГАТ

- Хөдөөгийн багуудад үүрэн холбооны сүлжээг нэвтрүүлэх
- Ерөнхий боловсролын сургуулийн их засвар хийх
- Сургуулийн 75 хүүхдийн дотуур байрыг барьж дуусган ашиглалтад оруулах
- Сумын ЗДТГ-ын барилгыг шинээр барих
- Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх худаг уст цэг барих
- Газар тариалангийн тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх

БАЯНТЭС

- Сумын төвийн инженерийн шугам сүлжээний зураг төсвийг гарган өргөтгөх
- Сумын төв доторх 2км авто зам барих /хатуу хучилттай/
- ЭМТ-ийн өргөтгөлийн барилгыг шинээр барих
- 100 хүүхдийн дотуур байр шинээр барих
- Нийтийн аж ахуй худалдаа үйлчилгээний төвийг хувийн хэвшлийг дэмжих бодлогын хүрээнд байгуулах
- Ахмадууд, залуучууд, гэр бүлийн хөгжлийн төв байгуулах



БАЯНХАЙРХАН

- ЭМТ-ийн барилгын ажлыг дуусгах
- Газар тариалангийн үйлдвэрлэлийг дэмжиж усжуулах,тоног төхөөрөмжөөр хангах
- Сумын ЗДТГ-ын барилгыг шинээр барих
- Бага оврын мах махан бүтээгдэхүүн боловсруулах,хадгалах үйлдвэр байгуулах

ДӨРВӨЛЖИН

- Сумын төвийн инженерийн шугам сүлжээний зураг төсвийг гарган өргөтгөх
- Ямааны сүүний үйлдвэрлэлийг байгуулахыг бодлогоор дэмжинэ
- Ингэний сүүний кластер байгуулна
- Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд ногоон төгөл, цэцэрлэгт хүрээлэн байгуулах



- Цогт, Онц багуудад үүрэн холбооны сүлжээг нэвтрүүлэх


ЗАВХАНМАНДАЛ

- Сумын төвийн инженерийн шугам сүлжээний зураг төсвийг гарган өргөтгөх
- Сумын төв доторх 2км авто зам барих /хатуу хучилттай/
- Соёлын төвийн барилгыг шинээр барих /спорт заал бүхий /
- Сум дундын эмнэлэгийн амбулаторийн барилгыг дуусгаж ,орчин үеийн оношлогоо шинжилгээний төхөөрөмжөөр хангах
- 320 хүүхдийн суудалтай сургуулийн барилгыг дуусгах, сургалтын техник тоног төхөөрөмжөөр хангах
- Бага оврын мал нядалгааны цех, хөргүүртэй агуулах байгуулах
- Ногоон хэрэм туслах зурвасыг өргөжүүлэх, мэргэжлийн боловсон хүчинээр хангах, усалгааны нэгдсэн системтэй болгох, жимс жимсгэнэ боловсруулах бага оврын үйлдвэр байгуулах
- Эмийн ховор ургамал хунчир хамгаалах шинээр тарималжуулах ажлыг бий болгох
- Байгалийн хадлангийн талбай хаших, хадлан бэлтгэх иж бүрэн техник тоног төхөөрөмжөөр хангах

ИДЭР

- Сумын төвийн инженерийн шугам сүлжээний зураг төсвийг гарган өргөтгөх
- Сумын төвийн авто замыг хатуу хучилттай болгож, явган зам, гэрэлтүүлгийг цогцоор нь шийдвэрлэх
- Сумын төвийн ундны усны хоёр худгийг ус цэвэршүүлэгчтэй болгох

- Мануустай, Загастай багуудад үүрэн холбооны сүлжээ нэвтрүүлэх
- Засаг даргын Тамгын газрын барилгын өргөтгөл, их засварын ажлыг хийх
- Эрүүл мэндийн төвийн ариун цэврийн байгууламжийг шийдвэрлэх
- Сургуулийн 100 хүүхдийн дотуур байрыг шинээр барих
- Сумын төвийг төв замтай холбох 12 км замыг барьж дуусгах
- Эрүүл мэндийн төвийг шүдний кабинеттэй болгож мэргэшлийн эмчтэй болгох



ИХ-УУЛ

- Сумын төвийн цэвэрлэх байгууламжийн техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулж хэрэгжүүлнэ
- Сүү сүүн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрлэлийг дэмжинэ
- Төв зам дагасан орчин үеийн үйлчилгээний төв байгуулахыг дэмжинэ
- 150 хүүхдийн дотуур байрын барилгын ажлыг дуусгах
- Хүүхдийн 2-р дугаар цэцэрлэгийн барилгыг өргөтгөн шинэчлэх
- Малын дайвар бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих
- Малын тэжээл тариалах ажлыг дэмжих, эрчимжүүлэх
- Тосонцэнгэл Их-уул сумын 35кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугамыг барих
- Сум доторх 3 км хатуу хучилттай замыг дагуулан явган хүний зам барих

НӨМРӨГ

- Сумын төвийн инженерийн шугам сүлжээний зураг төсвийг гарган өргөтгөх
- Сумын төв доторх 2км авто зам /хатуу хучилттай/
- 100 хүүхдийн цэцэрлэг шинээр барих
- 160 хүүхдийн хичээлийн байр спорт заал шинээр барих
- Эрүүл мэндийн төвийн их засвар
- Хөдөөгийн 2 багт үүрэн холбооны сүлжээний өргөтгөл хийх




ОТГОН

- Отгон сумын аялал жуулчлалын төлөвлөгөөг хийж жишиг сум болгох
- Сумын төвөөс Отгонтэнгэр хайрхан чиглэлийн 70 км хатуу хучилттай авто зам ТЭЗҮ улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийх
- Хөдөөгийн багуудад үүрэн холбооны хүртээмжийг нэмэгдүүлэх
- Өрхийн үйлдвэрлэлийг дэмжиж ЖДҮ эрхлэгчдийн бүтээгдэхүүн боловсруулах нэгдсэн төв байгуулах
- Отгон sumaас Баянхонгор аймгийн Баянбулаг сум хүртэлх авто замын засвар арчлалтыг тогтмолжуулах, цаашид сайжруулсан болон хатуу хучилттай авто замын зураг төслийг хийх
- Сумын төвийн ойролцоо отоглох цэг байгуулах
- Отгон сумын хэмжээнд хог хаягдлын менежментийг сайжруулах, иргэд айл өрхүүдэд хог хаягдлын талаарх ойлголтыг сургах, хэвшүүлэх хог хаягдлыг менежментийг сайжруулах хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ
- ЭМТ-д шүдний кабинет байгуулах, боловсон хүчинээр хангах

САНТМАРГАЗ

- Сумын төвийн инженерийн шугам сүлжээний зураг төсвийг гарган өргөтгөх
- Сумыг баруун чиглэлийн төв замтай хатуу хучилттай авто замаар холбох
- Суманд эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх
- 15 ор бүхий ЭМТ-ийн барилгыг шинээр барьж ашиглалтад оруулах
- Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд ногоон төгөл, цэцэрлэгт хүрээлэн байгуулах
- Сумыг газар тариалангийн талбайтай болгож техник тоног төхөөрөмжөөр хангах



СОНГИНО

- Соёлын төвийн барилгыг шинээр барьж ашиглалтад оруулах
- ЕБС-ын хүүхдийн дотуур байрыг шинээр барих
- Халуун ус бүхий үйлчилгээний төвийг шинээр барих
- Сумын ЗДТГ-ын барилгыг шинээр барих
- Сумын төвийн инженерийн шугам сүлжээний зураг төсвийг гарган өргөтгөх
- Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд ногоон төгөл, цэцэрлэгт хүрээлэн байгуулах


ТОСОНЦЭНГЭЛ

- Тосонцэнгэл сумыг хотын статустай болгох бодлого дэвшүүлж, “1 аймаг 2 хот” бодлого баримтлан ажиллана
- Тосонцэнгэлийн нисэх буудлыг иж бүрэн шинэчилж, тогтмол нислэг хүлээн авдаг болгоно
- Тосонцэнгэл хот дотор нийтийн тээврийн үйлчилгээг нэвтрүүлнэ
- Цэцэрлэгт хүрээлэн барих техник эдийн засгийн үндэслэлийг хийлгэж, ажлыг эхлүүлнэ
- Сумын төвд хатуу хучилттай замын их засвар болон Хайрхан, Улаантолгой, Дархан-Уул багуудад хатуу хучилттай авто зам шинээр барих.
- Тосонцэнгэлд сумд үерийн хамгаалалтын далан барих
- Тосонцэнгэл сумын Дархан-Уул, Хайрхан, Улаантолгой багуудад инженерийн шугам сүлжээний ажил хийх
- Хожуулын гол дээр төмөр бетон гүүр барих тийм
- Төрийн албан хаагчдыг орон сууцаар хангах хүрээнд 40 айлын орон сууцны төсөл хэрэгжүүлэх
- Тосонцэнгэл сумын ерөнхий боловсролын 2-р сургуульд ОУ-ын стандарт бүхий хөл бөмбөгийн талбай байгуулах
- Тосонцэнгэл сумын ерөнхий боловсролын 1-р сургуульд ОУ-н стандартын 3x3 сагсан бөмбөгийн талбай барих
- Тосонцэнгэл сумын ерөнхий боловсролын 1-р сургуулийн барилгын их засвар хийх
- Тосонцэнгэл сумын 4 дүгээр цэцэрлэгийн барилгын их засварыг хийх

- Тосонцэнгэл суманд Сүү хөтөлбөр хэрэгжүүлэх хүрээнд хөдөөгийн багуудын малчдын сүүг хадгалах хөргүүр бүхий агуулах барих

ТҮДЭВТЭЙ СУМ

- Сумын төвийг төв замтай хатуу хучилттай замаар холбох
- Сумын төвийн 1 худагт ус цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулах
- ЭМТ-ийг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах /дурс оношилгооны аппарат
- 100 хүүхдийн цэцэрлэгийн барилгыг ашиглалтад оруулах
- Сумын төвийн инженерийн шугам сүлжээний зураг төсвийг гарган өргөтгөх
- 250 хүний суудал бүхий соёлын төвийн барилгыг ашиглалтад оруулж техник, тоног төхөөрөмжөөр хангах
- Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд ногоон төгөл, цэцэрлэгт хүрээлэн байгуулах
- Цэвэр усны нөөц бий болгох гүний худаг гаргах



ТЭЛМЭН СУМ

- Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хийх
- Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд ногоон төгөл, цэцэрлэгт хүрээлэн байгуулах
- Сумын төвийн инженерийн шугам сүлжээний зураг төсвийг гарган өргөтгөх

- Хөдөөгийн багуудад үүрэн холбооны сүлжээний өргөтгөл хийх
- Сумын төвийн доторх хатуу хучилттай 3км авто зам барих
- Тосонцэнгэл Их-уул сумын 110кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугамыг барих
- Сумын ЗДТГ-ын баригыг шинээр барих


ТЭС СУМ

- Тэс сумыг эдийн засгийн чөлөөт бүс болгон хөгжүүлнэ
АДАСТАЙ 9039076
983100009
- Арц суурийн түний гаалийг-Тэс суманд барьж байгуулна
- Сумын төвд хатуу хучилттай 2км авто зам барих
- Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд ногоон байгууламж бүхий цэцэрлэгт хүрээлэн байгуулах
- Сумын төвд нэгдсэн цэвэрлэх байгууламжтай болох / цэвэр, бохир дулаан/
- ЕБС-д спорт заал шинээр барих
- Сургуулийн 50 хүүхдийн дотуур байр, 100 хүүхдийн гал тогоо барих /Зураг төсөв нь хийгдсэн/
- Сумын Эрүүл мэндийн төвд шүдний кабинеттai болох
- Сумын төвд нэгдсэн халуун ус бүхий үйлчилгээний барилга барих
- Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх / чацаарганы цехтэй болох
- Сумын төвийн инженерийн шугам сүлжээний зураг төсвийг гарган өргөтгөх
- Орчин үеийн усалгаатай тариалангийн талбай бий болгох

УЛИАСТАЙ

- Гэр хорооллын гудамжуудын авто зам, тохижилтыг ээлж дараатайгаар хийх
- Нийтийн орон сууцны барилгуудын гадна фасадыг шинэчилж, дулаан алдагдлыг бууруулах төсөл хэрэгжүүлнэ
- Авто зогсоолуудын хүртээмжийг нэмэгдүүлэх
- Богд, Чигэстэйн гол дагуу Ногоон байгууламж бүхий
- Соёл амралтын хүрээлэнг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барьж байгуулна
- Ногоон байгууламж нэмэгдүүлэх, ойжуулалт хийх
- Жинст багаас Өлзийт баг хүртэлх 290,3м урт төмөр бетон гүүр, авто зам байгуулах
- Улиастай хотод “1000 айлын орон сууц” хөтөлбөрийг хэрэгжүүлж, хувийн хэвшлийн дэмжлэгээр шинэ хорооллыг барьж байгуулна
- Улиастай хотод Богдын гол, Жинст, Жаргалант, Чигэстэй багуудын төв зам дагасан хашаа, орон сууцын төлөвлөлтийг шинээр хийж, жишиг гудамжуудыг байгуулна
- Төрийн үйлчилгээг цахимд шилжүүлнэ
- Хөдөлгөөний эрчим ихтэй газруудад хатуу хучилттай авто замыг шинээр барих
- Улиастай хотыг бүрэн камержуулж иргэдэд аюулгүй хот болгоно
- Цэвэрлэх байгууламжийг ашиглалтад оруулах
- Дулааны станцыг ашиглалтад оруулах
- Жинст, Богдын гол багуудын дулааны шугамын 2-р хэлхээний шинэчлэлтийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийнэ
- Хот доторх нийтийн тээврийн үйлчилгээг өргөжүүлж чиглэлийг нэмэгдүүлэн хүртээмжтэй болгоно

- Богдын гол багт “Гудамж” төсөл хэрэгжүүлэх
- Тохиромжтой байршилд мод мodon материал болон түүхий эдийн зах байгуулах
- Товцог багт 640 хүүхдийн сургуулийн барилгыг ашиглалтад оруулах
- Өлзийт багт 150 хүүхдийн цэцэрлэг, 640 хүүхдийн сургууль барьж байгуулах
- Улиастайн хэмжээнд хог хаягдлын менежментийг сайжруулах, иргэд айл өрхүүдэд хог хаяглдын талаарх ойлголтыг сургах, хэвшүүлэх хог хаягдлыг менежментийг сайжруулах хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ
- Жаргалант, Чигэстэй, Богдын гол, Жинст багийн ногоон хашаа орчмын үерийн даланг шинээр барьж байгуулна




УРГАМАЛ СУМ

- ЕБС-ийн 240 хүүхдийн орчин үеийн стандарт хангасан спорт заал бүхий хичээлийн байрыг шинээр барих
- Сумын төвийн инженерийн шугам сүлжээний зураг төсвийг гарган өргөтгөх
- Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд ногоон байгууламж бий болгон мод тарих санал санаачлагыг дэмжин ажиллах
- Хүнгий голын урд болон хойд гүүрийг төмөр бетон гүүртэй болгох
- 250хүний суудал бүхий Соёлын төвийг шинээр барьж ашиглалтанд оруулах
- Бэлчээрийн даацыг нэмэгдүүлж, худаг ус цэгийг гаргах
- Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хийх

ЦАГААНХАЙРХАН СУМ

- ЕБС-н 240 хүүхдийн багтаамж бүхий сургуулийн барилгыг шинээр барих
- Цэцэрлэг, Баянбулаг, Онц багуудад үүрэн холбооны сүлжээний өргөтгөл хийх
- 20тн багтаамж бүхий хөргүүртэй агуулах барих
- ЗДТГ-ын барилгыг шинээр барих тийм
- Соёлын төвийн барилгыг шинээр барих тийм
- Сумын төвийн инженерийн шугам сүлжээний зураг төсвийг гарган өргөтгөх
- Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд ногоон төгөл, цэцэрлэгт хүрээлэн байгуулах
- Төмөртийн голд төмөр бетонон гүүр барих




ЦАГААНЧУЛУУТ СУМ

- Улиастай, Говь-Алтай чиглэлд тавигдах босоо тэнхлэгийн авто замд Цагаанчuluут сумын төвийг холбох
- Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх, инженерийн хийцтэй болон энгийн уурхай худгийг шинээр гаргах болон сэргээн засварлах
- Сумын соёлын төвийн барилгыг шинээр барих
- Сумын төвийн цэвэрлэх байгууламжийг барьж байгуулах /зураг төсөл хийгдсэн/
- Сумын төвийн инженерийн шугам сүлжээний зураг төсвийг гарган өргөтгөх
- Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд ногоон төгөл, цэцэрлэгт хүрээлэн байгуулах

- Орчин үеийн усалгаатай тариалангийн талбайтай болох

ЦЭЦЭН-УУЛ СУМ

- Сумын төвийн инженерийн шугам сүлжээний зураг төсвийг гарган өргөтгөх
- Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд ногоон төгөл, цэцэрлэгт хүрээлэн байгуулах
- Засаг Даргын тамгын газрын барилгыг шинээр барих тийм
- Халуун ус бүхий үйлчилгээний төв барих тийм
- Хөдөө аж ахуйн техник тоног төхөөрөмжөөр хангах
- Хөв, цөөрөм, худаг, уст цэгийг нэмэгдүүлэх
- Сумын эрүүл мэндийн төвийн барилгыг шинээр барих




ШИЛҮҮСТЭЙ СУМ

- Гуулин тосгоны араар Завхан гол дээр орон нутгийн чанартай гүүр тавих /зураг төсөл хийгдсэн/
- Сумын төвийн инженерийн шугам сүлжээний зураг төсвийг гарган өргөтгөх
- Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд ногоон төгөл, цэцэрлэгт хүрээлэн байгуулах
- Бор ботгын пойлонд усалгааны систем байгуулж газар тариалангийн ажлыг эрчимжүүлэх
- ХАА-н техник тоног төхөөрөмжөөр хангах, хөв цөөрөм байгуулах

- Соёлын төвийн барилгыг шинээр барьж байгуулах
- Хөдөөгийн багуудад үүрэн холбооны сүлжээний өргөтгөл хийх

ЭРДЭНЭХАЙРХАН СУМ

- Мухартын голын эко паркийг байгуулж, сум нь хариуцдаг болох тогтолцоог нэвтрүүлнэ
- Хар нуурын аялал жуулчлалын мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх бодлого баримтлана
- Мухартын гол „Улаагчны хар нуурыг хамгаалах, аялал жуулчлалыг хөгжүүлэх“ Үүнд:
 - Био бие засах газар
 - Эрчим хүчний асуудлыг шийдвэрлэх
 - Камержуулалт
- Эрдэнэхайрхан сумын “Хайрхан” багт мэдээлэл холбооны гурвалсан үйлчилгээг нэвтрүүлнэ
- Эрдэнэхайрхан сумын төвийг цэвэр бохирын нэгдсэн шугамтай болгож, инженерийн шугам сүлжээтэй болгох
- Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд ногоон байгууламж бий болгон мод тарих санал санаачлагыг дэмжин ажиллах
- 75 хүүхдийн Цэцэрлэгийг шинээр барьж ашиглалтад оруулах
- Малчин болон хувиараа хөдөлмөр эрхлэгч нарын орлогыг нэмэгдүүлэх тал дээр “Шинэ Хоршоо” хөдөлгөөний хүрээнд дэмжин ажиллах



ЯРУУ

- Хатавчийн замаас Яруу сумын төв орох 30км хатуу тийм хучилттай

замын ТЭЗҮ-г улсын төсвийн хөрөнгө оруулалтаар тавих

- Хөдөөгийн багуудад үүрэн холбооний сүлжээний өргөтгөл хийх
- Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд ногоон байгууламж бий болгон мод тарих санал санаачлагыг дэмжин ажиллах
- Сумын төвийн инженерийн шугам сүлжээний зураг төсвийг гарган өргөтгөх
- Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх, инженерийн хийцтэй болон энгийн уурхай худгийг шинээр гаргах болон сэргээн засварлах
- Багуудад өвс тэжээлийн агуулахтай болох



ЗАВХАН АЙМГИЙН МОНГОЛ АРДЫН НАМЫИН ХОРОО